



Хөтөлбөрийн магадлан итгэмжлэл

ШИНЖЭЭЧИЙН ТАЙЛАН

ШУТИС-ийн Үйлдвэрлэлийн технологийн сургууль
Хөтөлбөр: Хэвлэлийн үйлдвэрлэлийн технологи, D072202

Шинжээчийн баг:

Ахлагч: **Ө.Ганбат**

Гишүүд: **С.Алтантуяа**

Д.Одсүрэн

2021.01.26

Агуулга

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургууль /Монгол, Англи/	ШУТИС-ийн Үйлдвэрлэлийн технологи дизайны сургууль School of Industrial Technology, MUST	
Хөтөлбөр /Монгол, Англи/	Хэвлэлийн үйлдвэрлэлийн технологи	Printing Technology
Индекс	072202	
Шинжээчид	Ө.Ганбат	ХААИС-ийн ИТС-ийн Механик инженерийн тэнхимийн эрхлэгч
	С.Алтантуяа	Монголын хэвлэлийн үйлдвэрүүдийн холбооны гүйцэтгэх захирал
	Д.Одсүрэн	СУИС-ийн РТМУС-ийн захирал
БМИҮЗ-ийн Мэргэжилтэн	Ж.Тунгалаг	
Төлөвлөгөө	Огноо	Хийгдсэн байх ажлууд
	2020.10.23	Мэргэжилтэн шинжээчдийн багийн бүрэлдэхүүнийг сонгож, ашиг сонирхлын зөрчилгүй болохыг тодруулах
	2020.10.27	Ажлын албаны захирал шинжээчийн багийг томиллох
	2020.10.28	Шинжээчтэй гэрээ байгуулан, өөрийн үнэлгээний тайланг хүлээлгэн өгч, урьдчилсан үнэлгээг эхлүүлэх
	2020.11.03	Шинжээчид урьдчилсан үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгөх
	2021.01.15	Мэргэжилтэн, шинжээчийн багийн ахлагч сургуульд очиж бэлтгэл хангуулах
	2021.01.18 2021.01.19	Шинжээчид цахимаар ажиллах
	2021.01.26	Шинжээчид үнэлгээний тайлан мэргэжилтэнд хүлээлгэн өгөх
	2021.01.28	Шинжээчийн үнэлгээний тайланг сургуульд илгээж, санал авна
	2021.02.01	Сургууль санал, тайлбар, нотлох баримтыг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	2021.02.03	Шинжээчид үнэлгээний тайланг эцэслэнэ
		Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанд шинжээчийн үнэлгээний тайланг хэлэлцүүлнэ.
Шалгуур шаардлага /журам/	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ы өдрийн 08 тоот тогтоолоор баталсан “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”-ын “Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур, шаардлага”-ыг баримтлав.	

II. ХЭВЛЭЛИЙН ҮЙЛДВЭРИЙН ТЕХНОЛОГИ БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨРИЙН ТАНИЛЦУУЛГА

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж		ШУТИС, ҮТС-ийн Хөнгөн Үйлдвэрлэлийн Технологи, Инженерчлэлийн Салбар				
Хөтөлбөрөөр анх элсэлт авч, сургалт эхлүүлсэн огноо		1998.09.01				
Хөтөлбөрийн (одоогийн) нэр		Хэвлэлийн үйлдвэрлэлийн технологи				
Хөтөлбөрийн индекс		D0722202				
Сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн дугаар, хүчинтэй хугацаа		960009 2025-03-02				
Сургалтын хэлбэр		Өдөр				
Суралцах хугацаа		4 жил				
Сургалт явуулдаг хэл		Монгол				
Хөтөлбөрийн өөрчлөлт (нэр, индекс, огноо)		MNS 5323-116: 2011, Дээд боловсрол. Мэргэжлийн чиглэл: Хэвлэлийн Үйлдвэрлэлийн технологи, Индекс: D541500				
Хөтөлбөрийн хороогоор батлагдсан огноо:		2014-07-02				
Багшлах бүрэлдэхүүний нийт тоо:		23				
Үүнээс	Үндсэн	11				
	Цагийн	-				
	Бусад	12				
Боловсролын зэрэг	Доктор	5				
	Магистр	6				
Албан тушаалын зэрэглэл	Профессор	1				
	Дэд профессор	3				
	Ахлах багш	6				
	Багш	1				
	Дагалдагч багш	-				
Ажлын туршлага	20-оос дээш жил	7				
	11-20	3				
	6-10 жил	1				
	5 хүртэлх жил	-				
Суралцагчдын нийт тоо		2020	2019	2018	2017	2016
		28	24	41	56	73
Үүнээс	4-р курс	15	11	14	21	27
	3-р курс	5	8	10	6	18
	2-р курс	-	5	10	15	7
	1-р курс	8	-	7	14	21
Төгсөгчдийн тоо			10	9	22	11
Хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагын хаяг, утас, цахим хаяг		ШинжлэхУхаанТехнологийнИхСургууль 15 тоотхаалга 11-р хороолол, Бага тойруу, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар, Монгол улс 14192 Ш/х: 46/590 Утас: (976)-11-324590-2917, 324590-2911, 96655561				
Хөтөлбөрийн хэрэгжилтийг хариуцагч эрх бүхий албан тушаалтан, түүнтэй холбогдох		Д. Батбаяр. ХҮТИ-ийн Салбарын эрхлэгч. Утас: 96655561				

хаяг, дугаар	
Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн давтамж:	Анх удаа

III. ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ

Шалгуур 1. ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Баримт нотолгоо

ШУТИС-ийн стратеги төлөвлөгөөний зорилтын хүрээнд “CDIO загварын турших, үйл ажиллагааг эхлүүлэх тухай” Ректорын 2013 оны тушаалыг үндэслэн боловсролын чиг хандлагыг баримжаалан сургалтын үйл ажиллагаа явуулж байгаа нь багш нартай хийсэн ярилцлага болон өөрийн үнэлгээний тайлангаар нотлогдож байна.

Хөтөлбөрийн хэрэгцээ шаардлагын тодорхойлох зорилгоор чиг хандлагын STEEP шинжилгээ хийж, төгсөгчдийн загвар гарган хөтөлбөрийн шинэчлэлийг хийсэн орчин үеийн боловсролын чиг хандлагыг баримталсан байна.

Мөн гадааддын тэргүүлэх 4-н их сургуулийн ижил төстэй мэргэжлийн хөтөлбөртэй харьцуулан өөрийн хөтөлбөрийн давуу болон дутагдалтай талыг үнэлж, хөтөлбөрийн макро орчны SWOT шинжилгээ хийсэн байдал нь олон улсын боловсролын чиг хандлагад нийцүүлэн оролцогч талуудын хэрэгцээг хангасан чиглэн хөтөлбөрийг боловсруулсан байна.

Шинжээчийн үнэлгээ:

Шинжилгээний олон төрлийн аргыг ашиглан төгсөгчдийн загварыг гарган суралцахуйн үр дүн тодорхойлсон нь оролцогч талууд хэрэгцээг хангахад чиглэсэн үйл ажиллалагаа явуулж байгааг харуулж байна.

Дүгнэлт: 1.1 шаардлагыг бүрэн хангасан байна.

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Баримт нотолгоо:

Үр дүнд суурилсан боловсролын нэг хэлбэр болох инженерийн салбарт хэрэглэдэг CDIO арга зүй, стандартыг баримтлан хөтөлбөрийн боловсролын зорилго, зорилтыг ШУТИС, Үйлдвэрлэлийн технологийн сургууль, Хөнгөн үйлдвэрлэлийн технологи, инженерчлэлийн салбарын зорилго, зорилттой /1.2.3-р хүснэгт/ нийцүүлэн боловсруулсан нь өөрийн үнэлгээний тайланд тусгагдсан байна. Мөн ажил олгогч болон салбарын хэлэлцүүлэг, төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгаа, багш нарын саналыг хөтөлбөр боловсруулахад оролцуулсан тухай нотлох баримт байна.

Шинжээчийн үнэлгээ:

Оролцогч талуудын хэрэгцээ, ажил олгогч болон салбарын хэлэлцүүлэг, төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгаа хийдэг боловч хөтөлбөрийн зорилго, зорилтыг баталгаажуулахад хэрхэн оролцуулж байгаа нь нотлох бичиг баримтаар батлагдахгүй байна.

Дүгнэлт: 1.2 -р шалгуурынг ХЭСЭГЧЛЭН ХАНГАСАН байна.

Шаардлага/ зөвлөмж

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Баримт нотолгоо:

Хөтөлбөрийг 2003, 2007 онд сургалтын төлөвлөгөөний түвшинд баталгаажуулж байсан бол “Хэвлэлийн үйлдвэрлэлийн технологи” хөтөлбөрийн MNS 5223-116:2011 стандартыг “Стандарт хэмжил зүйн үндэсний зөвлөл”-өөр 2011 онд баталгаажуулсан.

Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнд (PLO) суурилсан сургалт явуулж байгаа нь хичээлийн стандартад тусгасан хичээлийн суралцахуйн үр дүн (CLO), оюутан төвтэй, идэвхтэй сургалтын аргыг хэрэгжүүлж байгаа нь оюутан болон төгсөгч оюутантай хийсэн ярилцлагын жишээ баримтаар нотлогдож байна.

Хөтөлбөрийн хичээл дундын төслийн 4-н хичээлийн стандарт, төслийн удирдамжаар оюутны эзэмшсэн мэдлэгийн практик хэрэглээнд ашиглах, ур чадварыг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой байгаа нь харагдав.

Шинжээчийн үнэлгээ:

Хөтөлбөрийн оролцогч талуудын хэрэгцээ шаардлагыг хангахад чиглэсэн иж бүрэн баримт бичгийг БСШУ-ны сайдын 2014 оны А/174 тушаалаар баталсан “Бакалаврын хөтөлбөрт тавих шаардлага”-ын дагуу боловсруулан мөрдөж байна

Дүгнэлт: 1.3 шаардлагыг *БҮРЭН ХАНГАСАН* байна.

ШАЛГУУР 1. ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ:

ШУТИС нь Монгол улсын Их, дээд сургуулийн инженерийн чиглэлийн сургалтанд CDIO арга зүй, стандартын хэрэгжүүлэхэд манлайлан оролцож байгаа нь “Хэвлэлийн үйлдвэрлэл технологи” хөтөлбөрийн хэрэгцээ шаардлага, хөтөлбөрийн зорилго, зорилтыг тодорхойлох, хөтөлбөрийн бичиг баримтыг боловсруулах хялбар болсон байна.

Шинжээчийн дүгнэлт: Хөтөлбөрийн зорилго, агуулгад тавих шалгуурыг *БҮРЭН ХАНГАСАН* гэж дүгнэлээ.

Шаардлага:

1. Хөтөлбөрийн зорилго, зорилтыг ажил олгогч болон оролцогч талуудын төлөөлөл болох ажил олгогчдын зөвлөл, мэргэжлийн хөтөлбөрийн хороо зэрэг нэгжээр үе шаттай оролцуулж үнэлгээ дүгнэлт авч байх.

Зөвлөмж:

1. ШУТИС-ийн чанарын менежментийн тогтолцооноос гадна, хөтөлбөрийн зорилго, зорилт, суралцахуйн үр дүнг тасралтгүй сайжруулалт хийж байгааг нотлох “Хэвлэлийн үйлдвэрлэлийн технологи” хөтөлбөрийн бодлогын баримт бичигтэй байх

Шалгуур 2. СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Баримт нотолгоо:

Сургалтын агуулгын “Хэвлэлийн үйлдвэрлэлийн технологи” хөтөлбөрийн MNS 5223-116:2011 стандарт тусгаснаас гадна ажил олгогч, төгсөгч, мэргэжлийн холбоодтой хийсэн санал асуулга, хэлэлцүүлэг зохион байгуулах хэлбэрээр онол практикийн харьцаа, хичээлийн харилцан уялдааг тогтоож ирсэн нь багш нартай хийсэн ярилцлага, хэлэлцүүлгээс нотлогдож байна.

Хөтөлбөрийн агуулгын шинэчлэлийг сайдын А/174 тоот тушаалын дагуу хийж ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлөөр 2014 онд, “ШУТИС-ийн хөтөлбөрүүдэд CDIO загварыг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай” ректорын 2015 оны тушаалд хичээл хоорондын уялдаа холбоо, агуулгыг шинэчлэн 2017 онд сургалтын төлөвлөгөөг шинэчлэн баталгаажуулж, хөтөлбөрийг шинэчлэн боловсруулсан байна.

Ажил олгогчдын саналыг үндэслэн технологийн дадлага 1, 2-ийн хүрээнд 14 хоног хийдэг байсныг 21 хоног өөрчилсөн практикийн зохистой харьцаа бий болгоход чиглэн ажилласан байна.

Шинжээчийн үнэлгээ:

“Хэвлэлийн үйлдвэрлэлийн технологи” хөтөлбөрийг тасралтгүй сайжруулж байгаа нь бичиг баримтаар нотлогдож байна.

Дүгнэлт: 2.1 шаардлагыг *БҮРЭН ХАНГАСАН* байна.

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Баримт нотолгоо:

Хөтөлбөрийн боловсролын зорилгыг суралцахуйн үр дүн болон хичээлүүдтэй холбосон матриц боловсруулж үр дүнд суурилсан сургалт явуулж байна. Хөтөлбөрийн багш нарыг “Дээд боловсролыг шинэчлэл төсөл”-ийн хүрээнд CDIO арга зүй, стандартын 9-н удаагийн сургалтанд хамруулсан нь батламжаар нотлогдож байна. Мэргэжлийн хичээл зохион байгуулахад идэвхитэй сургалтын арга ашиглан байгаа нь төгсөх ангийн оюутнуудтай хийсэн ярилцлага, хичээл дундын төслийн хичээлийн удирдамжаар батлагдаж байна.

Багш нарын заах арга зүйг хөгжүүлэх, хяналт тавих зорилгоор нээлттэй хичээлийн хуваарь гарган дэд захирлаар баталгаажуулсан байна. Мөн багшийн хичээлд сууж зөвөлгөө өгсөн тэмдэглэл багшийн журналд тэмдэглэсэн байна.

“Хэвлэлийн үйлдвэрлэлийн технологи” мэргэжлийн хөтөлбөрийг боловсролын зорилго, зорилготой нийцүүлэн, хичээлийн агуулгын давхцлыг арилган ШУТИС-ийн UNIMIS системд оруулснаар оюутнууд харилцаа холбооны дэвшилтэд технологийн ашиглах боломжийг бүрдүүлж байна.

ШУТИС-ийн UNIMIS системийн онлайн сургалтын платформ болох LMS нь онлайн сургалтын гол суурь болдог. LMS нь багшийн болон оюутны веб-ээс шууд хандалт хийх боломжтой. Багш хичээлийн лекц, семинар, лабораторийн зааврыг оруулан оюутан хэзээ, хаанаас ч хандах боломжийг бүрдүүлсэн. Мөн үүрэн телефоны оператор компаниуд ШУТИС-ийн багш, оюутны веб, LMS-д холбогдоход дата үнэгүй үйлчилгээг нэвтрүүлсэн. Энэ системд тухайн хичээлийн стандарт, агуулга, лекц, семинар, лабораторийн зааврыг цахим хэлбэрээр (PPT, PDF), 25 MB хүртэл хэмжээтэй видео материалыг оруулах боломжтой.

2019-2020 оны хичээлийн жилийн хаврын улиралаас MS-TEAMS-ийг ШУТИС сургалтандаа ашиглаж эхэлсэн. Энэ платформын давуу тал нь онлайн, офлайн, чат, видео чат, хичээлийн файл, видео файл зэргийг өндөр чанартайгаар оруулж ашигладаг. Мөн тухайн хичээл сонгосон оюутны ирц, явцын болон улирлын эцсийн шалгалтуудыг уг платформыг дэмжигч программуудын тусламжтай аван үнэлгээг шууд хийх боломжийг бүрдүүлсэн. Онлайн хичээл хийхэд оюутны тооны болон цагийн хязгааргүй байдаг.

Шинжээчийн үнэлгээ:

Хөтөлбөрийн зорилгод нийцүүлэн үр дүнд суурилсан сургалт явуулдаг CDIO арга зүй стандартыг нэвтрүүлж, багш сургалтын хөтөлгөч, суралцахуйг зохион байгуулагч, судлаач багш зарчим тулгуурлан заах арга зүй нь өөрчлөгдсөн байна.

Дүгнэлт: 2.2 шаардлагыг *БҮРЭН ХАНГАСАН* байна.

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Баримт нотолгоо:

ШУТИС нь БСШУЯ-ны сайдын 2003 оны 158 тоот “ Дээд боловсролын зэрэг олгох сургалтанд багц цагийн хэрэглэх, суралцагсадын мэдлэг чадварыг дүгнэхэд баримтлах журам” тушаалыг үндэслэн боловсруулсан дүрэм, журмыг мөрдөн ажиллаж байна. Оюутны мэдлэг ур чадварыг “ Бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”-ын дагуу үнэлдэг. Оюутны эзэмшсэн мэдлэг, ур чадвар, хандлагыг 2 шаттай үнэлэх ба хичээл заасан багшаас 70 оноо, улирлын шалгалтаар 30 оноо өгдөг.

Хөтөлбөрийн боловсролын зорилго, зорилтын 3-р хүрээнд “ёс зүйтэй, хариуцлагатай байх” ур чадварыг S.SS102 Монголын түүх, S.SS115 Хүний хөгжил, S.SS113 Сэтгэл судлалын үндэс, S.SS109 Соёл судлалын үндэс. S.ML 103 Хэл ярианы соёл хичээлүүдээр олгодог. Энэ хичээлүүдээр тухайн оюутны хувь хүний төлөвшлийг хангахад зориулагдсан ба үнэлгээг тухайн оюутны семинар хичээлийн дүн, бие даалтын ажил гүйцэтгэлээр хийж байгаа нь оюутны даалгавар, багшийн үнэлгээгээр харагдаж байна.

Төгсөлтийн ажил, үйлдвэрлэлийн дадлага хийхдээ инженерийн асуудлыг тодорхойлох үйлдвэрийн газартай хамтарсан төгсөлтийн ажил хийдэг талаар ажил олгогчдын уулзалтын үеийн сайн жишээ болон дурьдагдаж байсан.

Шинжээчийн үнэлгээ:

ШУТИС-ийн бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохицуулах журмын дагуу оюутны мэдлэг, чадвар, хандлагыг үнэлж, голч дүнд шинжилгээ хийж тасралтгүй сайжруулж байна.

Дүгнэлт: 2.3 шаардлагыг *БҮРЭН ХАНГАСАН* байна.

ШАЛГУУР 2. ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ:

Хичээлийн агуулгыг шинэчлэн, идэвхтэй сургалтын арга ашиглан сургалтыг явуулж, журмын дагуу оюутныг үнэлж байгаа нь сургалтын үйл ажиллагааг тасралтгүй сайжруулж байгааг харуулж байна.

ШУТИС-ийн Үйлдвэрлэл технологийн сургууль 2019-2020 оны хичээлийн жилийн хаврын улирлаас сургалтын үйл ажиллагаанд MS-TEAMS-ийг ашиглаж эхэлсэн нь цахим сургалт явуулах боломжийг олгосон.

Шинжээчийн дүгнэлт: Сургалтын үйл ажиллагаанд тавих шалгуурыг *БҮРЭН ХАНГАСАН* байна.

Шалгуур 3. ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ОРЧИН, НӨӨЦ

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Баримт нотолгоо:

Хөтөлбөрийн сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлангийн өрөөний талбайн хэмжээ нь БСШУ-ны сайдын 2007 оны 05 тоот тушаалын 02 дугаар хавсралтад заасан шаардлагыг хангаж байна.

ШУТИС-ийн хэвлэлийн газрын үйл ажиллагааг зохицуулах журам /2018 оны 01 сарын 18ны өдрийн захирлын тушаал болон хавсралт/-д оюутны дадлага ажлыг гүйцэтгэх талаар дурьдаагүй ба оюутнуудтай ярилцсан ярилцлагаас үзэхэд ШУТИС дээр дадлага ажлыг хийх хугацаа маш бага байдаг байна.

Зарим хэвлэлийн мэргэжлийн нарийн технологийн багаж, тоног төхөөрөмж байхгүй учир дадлагын хичээлүүдийг ажил олгогч нартай гэрээ байгуулан хийдэг болох нь Ажил олгогчийн үйлдвэр дээр оюутнуудын ирц болон хийсэн ажлын баримт бичгээс харагдаж байна.

Шинжээчийн үнэлгээ:

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагыг хангасан гэж үзэж байна.

Дүгнэлт: 3.1 шаардлагыг *БҮРЭН ХАНГАСАН* байна.

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Баримт нотолгоо:

Сургалт болон дадлага ажил, лабораторийн ажлыг явуулах сургалтын тоног төхөөрөмж болон материал хангамжийн төслийг сургуулийн төсөвт суулгадаг талаар тэнхимийн эрхлэгчээр баталгаажуулсан албан бичгээс харагдаж байна.

Оюутнуудтай хийсэн ярилцлагаас үзэхэд лаборатори болон урлан, тоног төхөөрөмжийн автоматжуулалтын лаборатори өрөөнүүдэд цахилгааны залгуур цөөн учир хамтран нэг компьютер дээр ээлжлэн сууж ажиллах, түүнчлэн байгаа 50 компьютерийн хүчин чадал нь хоцрогдсон, эх бэлтгэлийн парактик ажлыг хийхэд шаардлага хангахгүй учир өөрсдийн нөүтбүүкийг авчран хичээлдээ суудаг байна.

Хичээлийн хөтөлбөртэй уялдлуулан хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөөний дагуу хийсэн дадлага ажлын гүйцэтгэлийг оюутнуудын дадлага ажлаар хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, хэвлэлийн бүтээгдэхүүний загварууд баталж байна.

Үйлдвэрлэлийн дадлагыг хийх заавар удирдамж, сургуулийн талаас удирдах удирдагчийг сургалтын албанаас баталгаажуулж, ажил олгогчидтой гэрээ байгуулан ажилладаг ба оюутнуудын дадлага ажлын тайлан гаргуулдаг талаар багш болон ажил олгогчидтой хийсэн уулзалт, тэдэнтэй байгуулсан гэрээнээс харагдаж байна.

Төгсөгчидтэй хийсэн уулзалт, ярилцлагаас үзэхэд үйлдвэрлэлийн сургалтын ажлыг зохион байгуулахдаа ажил олгогчидтой хийх гэрээг чанаржуулах шаардлагатай гэж үзэж байна.

Шинжээчийн үнэлгээ:

Сургалтын хөтөлбөрийн дагуу сургалтанд зайлшгүй шаардлагатай сургалтын хэрэглэгдэхүүн, материал, багаж төхөөрөмжөөр хангадаг ч энэ нь сургалтыг ялангуяа нарийн мэргэжлийн лаборатори ба дадлагын хичээлийг илүү үр дүнтэй явуулахад хангалтгүй байна. жишээ нь, цаасны жин, цаасны нягт үзэх бааж, өнгийн нягт хэмжих спектрофотометр багаж гэх мэт.

Дүгнэлт: 3.2 шаардлагыг **ХЭСЭГЧЛЭН ХАНГАСАН** байна. Шаардлага, зөвлөмж

1. Сургуулийн төсөвт суулгуулан сургалтанд зайлшгүй шаардлагатай, өндөр хүчин чадалтай компьютертой болох

2. ШУТИС-ийн хэвлэлийн газарт дадлага хийдэг тухай тайланд бичигдсэн боловч үйлдвэрийн машин, тоног төхөөрөмж ажиллах цагийн тоог нэмэх, дадлагажигч нарын ажиллах өдрийн тоо, хугацааны талаар ШТУИС-ийн хэвлэлийн газартай гэрээ байхгүй байна.

3.3. Сурах бичиг, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Баримт нотолгоо:

Номын сангаар үйлчлүүлэх орчин стандартын шаардлагыг бүрэн хангасан байртай, хэвлэлийн мэргэжлийн ном, сурах бичгийн фондтой байгаа талаар өөрийн үнэлгээний тайлангийн мэдээллээс харагдаж байна.

Хэвлэлийн мэргэжлийн ном, гарын авлагыг багш нар өөрсдөө орчуулан гаргадаг ба мэргэжлийн ном хэвлэлийг эрхлэн гаргах төлөвлөгөөтэй байгаа нь багш нартай уулзсан уулзалтаас харагдаж байна.

Оюутнуудаас авсан ярилцлагаас үзэхэд хэвлэлийн мэргэжлийн ном, сурах бичгээс оюутнууд хэрэгтэй мэдээллээ хангалттай авч чаддаг байна.

Ном, сурах бичгийн тоог нэмэх дээр багш нарын зүгээс анхаарч ажилладаг нь номын санд байгаа ном, сурах бичгүүдийн нэрсийн жагсаалт, ашигласан байдал, цахимаар үзэх ном хэвлэлийн стандартуудын жагсаалтууд болон багш нарын орчуулан гаргаж байгаа номуудын талаархи мэдээллээс батлагдаж байна.

Шинээр гарч байгаа ном, хэвлэлийн стандартуудын талаар онолын хичээл дээр цухас дурдаад өнгөрдөг талаар оюутан болон төгсөгчдөөс хийсэн асуулт ярилцлагаас харагдаж байна.

Оюутнуудын ном ашиглалтын судалгаанаас харахад /2015-2019он/ ном эх бэлтгэлийн чиглэл ялангуяа бичвэр мэдээлэл боловсруулах технологи номын их хэрэглэсэн байна. Энэ нь өөр бусад хичээлийн технологийн мэдлэг, мэдээлэл олж авахад дутагдалтай байгааг харуулж байна.

Шинжээчийн үнэлгээ:

Номын фондын шинэчлэл сүүлийн жилүүдэд багассан, гадаадын хэвлэлийн мэргэжлийн сэтгүүл, гарын авлагын баяжуулалт бага, багш нарт мэргэжлийн ном орчуулахад, хэвлэхэд туслалцаа дэмжлэг байдаггүй, сүүлийн үеийн хэвлэлийн дэвшилтэт технологи, өсөж байгаа хэвлэлийн технологийн талаархи ном, гарын авлага бага байна. Хөтөлбөрийн хуудас 104-107д мэргэжлийн номын жагсаал ба ашигласан номын судалгааг харахад сав баглаа боодлын технонологи, UV хэвлэлийн технологи зэрэг номууд 1-2ш байна. 2015-2019 онд хамгийн их авч уншсан номууд бол “Бичвэр мэдээлэл боловсруулах технологи” номыг 52-90 удаа ашигласан байна.

Дүгнэлт: 3.3 шалгуурыг *ХЭСЭГЧИЛЭН ХАНГАСАН* байна.

Шаардлага, зөвлөмж

1. Мэргэжлийн гадаадын цахим номын мэдээллийн сан, мэдээллийн үүсвэрийг бий болгож, сүүлийн үеийн хэвлэлийн шинэ технологийн талаархи ном, сурах бичгийн тоог нэмэх

ШАЛГУУР 3. ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ:

Сургалтын орчин, сургалтын хэрэглэгдэхүүн, сургалтын үзүүлэн таниулах материал хангалттай, багаж төхөөрөмж, мэргэжлийн номын фонд зэрэг нь суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцтэй бүрдүүлсэн байна.

Шинжээчийн дүгнэлт: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, нөөцөд тавих шалгуурыг *ХЭСЭГЧЛЭН ХАНГАСАН* байна.

Шаардлага:

1. Сүүлийн үеийн дэвшилтэт болон өсөн нэмэгдэж байгаа хэвлэлийн технологийн талаархи ном, гарын авлагыг нэмэгдүүлэх

Зөвлөмж

1. Лабораторийн нэг суудалд ноогдох стандарт талбайгаас бага /1.07м², 1.2м², 1.60м²/ байгаа нь суралцагчдын суралцах таатай орчинг сайжруулах, өрөөний талбайг нэмэх

2. Комьютерийн тоог нэмэх, хүчин чадлыг сайжруулах, лаборатори болон дадлагын хичээлийн материалын төрөл зүйлийг нэмэх.

3. Үйлдвэрлэлийн дадлагын ажлыг үйл явц, тайланг чанаржуулах, бүхий л мэдээллийг хангасан ирц, өдөр тутмын дадлагын ажлаар хийх сэдэв, юу сурч мэдсэн, юу хийсэн, яаж ажилласан, ажилд хандах хандлага зэрэг олон үзүүлэлтээр боловсруулсан оюутан тус бүрт дэвтэртэй /А4 товхимол/ болох

Шалгуур 4. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежмент, маркетингийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Баримт нотолгоо:

Багш нарын ихэнх нь мэргэжлийн гадаад, дотоодын их дээд сургууль төгссөн, мэргэжлээрээ 15-аас дээш жил ажилласан туршлагатай, зарим багш нар өмнө нь хэвлэлийн үйлдвэрт ажиллаж байсан нь багш нарын анкет болон ШТУИС-ийн ректорын багшлах бүрэлдэхүүний тушаалууд /2016-2019 он/-аас харагдаж байна.

Багш нар мэргэжил дээшлүүлэх сургалт, семинарт байнга хамрагддаг нь гэрчилгээ болон яам, төрийн байгууллагуудтай хийсэн гэрээ ба ажлын хэсгийн тушаалаар нотлогдож байна.

Төгсөгчид болон ажил олгогчдтой хийсэн ярилцлагаас харахад хөтөлбөрийн мэргэжлийн хичээлүүд нь оюутнууд төгсөөд ажилд ороход мэдлэг, чадварын хувьд бусад ажил горилогчдоос илүү байгааг нотолж байна. Нөгөө талаас оюутнууд төгсөөд яг технологич мэргэжлээр ажиллаж байгаа нь цөөн, ихэнхидээ хэвлэлийн дизайнер, хэвлэгчээр ажиллаж

байна. Энэ нь жижиг, дунд хэвлэлийн үйлдвэрүүд манай улсын 60-70 хувийг эзэлж байгаатай холбоотой. Өөрөөр хэлбэл, том үйлдвэрүүдэд хэвлэлийн технологич мэргэжлийн ажилтан байдаг бол жижиг, дунд үйлдвэрүүдэд бараг байхгүй байна. Нөгөө талаас хөтөлбөрийн нэршил зөвхөн нэг талаа барьсан учраас ажил эрхлэлт болон элсэгчдийн тоонд нөлөөлж байна.

Мөн төгсөгчидтэй хийсэн ярилцлагаас үзэхэд зарим нэг хичээл жишээлбэл, эх бэлтгэлийн талаархи онолын хичээл маш бага голчлон программ хангамжийн талаар заадаг учир үйлдвэр дээр гараад тухайн бүтээгдэхүүний эхийг бэлтгэхэд мэдлэг, чадвар дутагдалтай байсан гэжээ.

Шинжээчийн үнэлгээ:

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэсэн, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангахад гүйцэд чиглэгдэж чадахгүй байна.

Дүгнэлт: 4.1 шаардлагыг *ХЭСЭГЧИЛЭН ХАНГАСАН* байна.

Шаардлага, зөвлөмж:

1. Хөтөлбөрийн агуулга, хичээлийн цагийг шинэчлэх, ялангуяа оюутнууд төгсөөд ямар ажил дээр түлхүү ажиллаж байгаатай уялдуулан өөрчлөх шаардлагатай байна.

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Баримт нотолгоо:

Хэвлэлийн компаниудтай байнгын харилцаатай /уулзалт семинар, ярилцлага, санал асуулга, дадлага хийлгүүлэх гэх мэт/ хамтран ажилладаг нь ажил олгогч нартай хийсэн гэрээнээс харагдаж байна.

Мэргэжлийн холбоодтой хамтран мэргэжлийн сургалт, семинар зохион байгуулахад оролцох, уулзалт хийх, хамтран арга хэмжээ зохион байгуулах, дидломын хамгаалт дээр ажил олгогчдоос урьж оролцуулан ажилууллуудаг талаар мэргэжлийн холбоодтой хийсэн гэрээ, хамтран ажиллах саналаар батлагдаж байна.

Холбогдох Яамнаас зохион байгуулж байгаа ажилд багш нараас, удирдлагын зүгээс байнга оролцдог талаар яамны албан бичиг, тушаал зэргээр нийгэмд үзүүлэх үйлчилгээ нь харагдаж байна.

Хэвлэлийн компаниудын хүсэлтээр үйлдвэр дээр очиж мэргэжлийн зөвлөгөө өгдөг талаар ажил олгогчидтой хийсэн уулзалтаас батлагдсан.

Өөрийн үнэлгээний тайлангаас мөн багш нартай уулзсан уулзалтаас үзэхэд гадаадын ижил төстэй байгууллагуудтай хамтран ажилласан туршлага бага ба 2017 оноос хойш бүр зогссон талаар дурджээ.

Шинжээчийн үнэлгээ:

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дотоодын болон олон улсын их, дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоон хамтран ажиллаж, үйл ажиллагааныхаа хүрээг нэмэгдүүлэх, нийгэмд үзүүлэх үйлчилгээний хүрээнд бодитой ажлууд хийгдсэн байна.

Багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байгаа нь багш, суралцагчдын идэвхийг дээшлүүлэх, мэргэжлийн чадвхийг нэмэгдүүлэхэд үр дүнгээ өгч байна.

Дүгнэлт: 4.2 шаардлагыг *бүрэн хангасан* байна.

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Баримт нотолгоо:

ШТУИС-аас төсөвлөдөг сургалтын материаллаг бааз, лабораторийн тоног төхөөрөмжийн зардал өссөн нь багшийн болон материал тоног төхөөрөмжийн санхүүжилтийг баталсан ШУТИС-ын ректорын баримт бичгээс харагдаж байна. Ажил олгогчоос материаллаг баазыг дээшлүүлэхэд хандив, туслалцаа үзүүлдэг, түүнчлэн өөрсдийн нэрэмжит тэтгэлгийг бий болгох үйл ажиллагааг эхлүүлсэн нь ажил олгогчоос ирүүлсэн албан бичгээр батлагдаж байна. Сургуулийн зүгээс багш нарын мэргэжил дээшлүүлэх, ном, сурах бичгийн эх зохиоход дэмжлэг үзүүлдэг нь ШУТИС- аас баталсан санхүүжилтийн баримт бичгээс харагдаж байна.

Шинжээчийн үнэлгээ:

Сургуулийн зүгээс хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувийг багш, суралцагчийн хөгжилд зарцуулж байгаа нь багш, суралцагчдийн үйл ажиллагааг дээшлүүлэх нэг үүсвэр болж байна. Мөн хөтөлбөрт олон эх үүсвэртэй байна гэж заасан боловч санхүүжилтийн эх үүсвэр тоо цөөн байна.

Дүгнэлт: 4.3 шаардлагыг *БҮРЭН ХАНГАСАН* байна.

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Баримт нотолгоо:

Мэргэжил сурталчихад цахим сурталчилгааг ашигладаг, жил бүр профессорын багийн семинарыг зохион байгуулдаг нь өөрийн үнэлгээний тайлангаас болон багш нартай хийсэн уулзалт ярилцлагаас батлагдаж байна.

Бусад ижил төрлийн МСҮТ, коллеж, дээд сургуулиудаас оюутан элсүүлэх боломжийг судлан хамтран ажиллахаар төлөвлөн ажлаа эхлүүлсэн нь хийсэн төлөвлөгөөнөөс харагдаж байна.

Ажил олгогчоос ямар мэргэжлийн боловсон хүчин шаардлагатай байгаа талаар авсан санал нь баримтаар батлагдаж байна.

Оюутнуудтай хийсэн уулзалтаас үзвэл, мэргэжлийн талаархи маркетингийн идэвхжүүлэлт үр дүн муу байдаг гэж үзэж байна.

Нөгөө талаас оюутны тоог нэмэх тал дээр хийсэн дүн шинжилгээ, түүнчлэн тусгайлсан идэвхжүүлэлтийн цогц хөтөлбөр байхгүй байгаа нь удирдлага, багш нартай хийсэн ярилцлагаас харагдаж байна.

Шинжээчийн үнэлгээ:

Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлтийн олон төрлийн арга хэмжээнүүдийг зохион байгуулсан боловч хөтөлбөр төлөвлөгөө дутмаг байна.

Дүгнэлт: 4.4 шаардлагыг *хэсэгчлэн хангасан* байна.

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Баримт нотолгоо:

Хөтөлбөрийн талаар олон нийтэд нээлттэй, ил тод цахимаар сурталчилдаг талаар багш

нараас авсан мэдээллийг цахим хаягаар орж танилцсан болно.

Хөтөлбөрийг төлөвлөгөө гарган хөдөө орон нутаг, ЕБС-уудад уулзалт, семинар маягаар зохион байгуулдаг талаар өөрийн үнэлгээний тайланд дурджээ.

Багш нарын уулзалтаас жил бүр мэргэжил сурталчилах чиглээр төсөвт 3,0-4,5 сая төгрөгийг суулгадаг гэсэн боловч албан ёсны баталгааг үзүүлээгүй.

Шинжээчийн үнэлгээ:

Хөтөлбөрийг нээлттэй ил тод байлгахад анхаарч, өөрийн үйл ажиллагааны талаар нийтэд нээлттэй, үнэн зөв мэдээллийг ил тод хийсэн байна. Тухайлбал, элсэгч, төгсөгчдийн тоо

Дүгнэлт: 4.5 шаардлагыг *бүрэн хангасан* байна.

ШАЛГУУР 4. ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ:

Хөтөлбөрийн удирдлага үйл ажиллагаа, хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ, хөтөлбөрийн санхүүжилт, маркетингийн идэвхижүүлэлт, нээлттэй ил тод байдлын талаар хийсэн ажлууд болон үйл ажиллагаанууд нь цаг үеэ дагаад өөрчлөгдөх, өөрсдийн сул талаа анхааран боломж дээр суурилсан төсөл, хөтөлбөр гарган ажилласан байна.

Хөтөлбөрийн нэрийг зах зээлийн өнөөгийн байдалд нийцүүлэн өөрчлөөгүйгээс бэлтгэгдсэн боловсон хүчнүүдийн ихэнхи нь хэвлэлийн эх бэлтгэгч дизайнер, хэвлэгчээр ажиллаж байгааг анхаарч, мэргэжил сурталчлах, маркетингийн идэвхжүүлэлт хийх нь чухал байгааг ажил олгогчий төлөөллүүд ярьж байна. Сургалтын төлөвлөгөөнд сонгон суралцах мэргэжлийн хичээлийг олон сонголттойгоор оруулж, оюутан төгсөөд хэвлэлийн үйлдвэрлэлийн аль мэргэжлээр суралцах боломжийн хангаж өгөх.

Шинжээчийн дүгнэлт: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалтад тавих шалгуурыг **БҮРЭН ХАНГАСАН** байна.

Шаардлага:

1. Хөтөлбөрийг марктенгийн идэвхжүүлэлтийн 5-н үндсэн зарчимд тулгуурлан /зар суртчилгаа, борлуулалтын урамшуулал, биечлэн худалдаа, олон нийтийн, шууд марктенгийн/ нэгдсэн хөтөлбөр гарган боловсруулах.

Зөвлөмж:

1. Мэргэжлийн багш нарын тоог нэмэх замаар хэвлэлийн шинэ технологийн хичээл оруулах, мөн хичээлийн агуулга, арга зүйг сайжруулах, дадлагын хичээлүүдийг нэмэгдүүлэх
2. Олон улсын төсөл, хөтөлбөрүүдтэй хамтран ажиллаж, санхүүжүүлэлтийн нэмэлт эх үүсвэртэй болох боломжийг судлаж ажиллах

Шалгуур 5. СУРАЛЦАГЧИД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Баримт нотолгоо:

Дээд боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, БШУ-ны сайдын 2013 оны А/79 тоот тушаалаар баталсан “Оюутан элсүүлэх журам”-ыг баримтлан уг хөтөлбөрт оюутан элсүүлдэг.

ШУТИС-ийн элсэлтийн журамд мэргэжлийн чиглэлээр уралдаан тэмцээнд амжилт гаргасан элсэгчдэд зориулан хөнгөлөлт үзүүлдэг. Үүнд дараах журмын заалтыг үндэслэдэг:

- Мэргэжийн болон техник-технологийн улсын олимпиадад I,II,III байр эзэлсэн бол тухайн чиглэлээр шууд элсүүлэн суралцуулна.
- Бүс нутаг болон хотын олимпиадад I-X байр эзэлсэн бол мөн шууд элсүүлэн суралцуулна.
- Дээд боловсролтой иргэн ШУТИС-д хоёр дахь дээд боловсрол эзэмшихийг хүсвэл эцнээ сургалтанд шууд элсүүлэн суралцуулна.

Хөтөлбөрт оюутан элсүүлэх элсэлтийн ерөнхий шалгалтын босго оноо нь сүүлийн 5 жилийн байдлаар харвал 2015-2016 онд математик 440, физик 440 байсан бол 2016-2017 онд дээрх хоёр хичээлийн шалгалтын дүн тус тус 400 болж буурсан. 2017-2018 онд математик 480, физик 400 болон өөрчлөгдсөн байна. Харин 2018-2019 оноос математик 480, хоёр дахь хичээл нь физик, англи хэл, нийгэм, хими хичээлүүдийн аль нэг нь 400 оноо байхаар ЭЕШ өгөх хичээлийн сонголтыг нэмэгдүүлжээ.

Сүүлийн 5 жилийн элсэлтийн байдлыг авч үзвэл 2015-2016 онд 7 элсэгч, 2016-2017 онд 23 элсэгч болон өссөн байна. 2017-2018 онд 14 болон буурч, 2018-2019 онд 7 элсэгчийг элсүүлсэн нь дахин буурсан үзүүлэлт байв.

2021 оноос элсэгчдийн тоо өсөх урьдчилсан таамаглалыг гадаад, дотоод хүчин зүйл болон тоон мэдээллүүдэд үндэслэн гаргасан байна. Энэхүү таамаглал тооцооллоор ирэх 3 жилд элсэлтийн тоо 2020-2021 онд 12, 2021-2022 онд 15, 2022-2023 онд 18 элсэгчийг элсүүлэх боломжтой байна.

Шинжээчийн үнэлгээ:

Оюутны эрэлт буурч байгаа нь салбарын хөгжлийн бодлогын алдаа болон багцын хөтөлбөрийн элсэлтийн улмаас оюутнуудад бүрэн мэдээлэл хүрч чадахгүй байгаа шалтгаантай хэмээн үзэж байна.

Оюутны элсэлтийн урьдчилсан таамаглалыг дэвшүүлсэн нь сайшаалтай ч цаашид нэг бүлгийн оюутны тоог 25 байхаар тооцож, элсэлтийн сурталчилгааг хүртээмжтэй хийх, хөтөлбөрийн нэр хүндийг дээшлүүлэх чиглэлээр багц ажлыг төлөвлөн хэрэгжүүлж, элсэлтийг тогтвортой барих бодлогыг хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай.

Дүгнэлт: 5.1 шаардлагыг *БҮРЭН ХАНГАСАН* байна.

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Баримт нотолгоо:

ШУТИС-ийн үйл ажиллагаа нь UNIMIS удирдлагын мэдээллийн системд суурилан зохион байгуулдаг. Шинэ элсэгчдэд зөвлөх багшийг томилон ажиллуулдаг. Зөвлөх багш нь оюутны суралцах үйл ажиллагаатай холбоотой асуудлуудад зөвлөн туслах үйлчилгээг үзүүлдэг.

2011 оноос эхлэн сургалтын үйл ажиллагаа, сургалтын төлөвлөгөө, оюутанд холбогдох дүрэм журмуудыг багтаасан “Оюутны гарын авлага”-ыг жил бүр хэвлүүлэн оюутан бүрт олгодог байсан. 2019-2020 оны хичээлийн жилээс энэхүү гарын авлагыг цахим хэлбэрт шилжүүлэн оюутны вэбээр дамжуулан хүргэдэг болсон. Мөн ШУТИС-ийн вэбийн оюутан булангийн оюутанд өгөх зөвлөгөө зөвлөмж хэсэгт “Багш, оюутан” хөтөлбрийг 2016 оноос хойш хэрэгжүүлж эхэлсэн. Үүгээр дамжуулан сургалтын үйл ажиллагаа, лаборатори, анги танхим, номын сан, оюутны үйлчилгээний талаарх үйлчилгээтэй холбоотой мэдээллийг байршуулдаг.

ШУТИС-ийн оюутны холбоо нь <http://oyutan.must.edu.mn> вэб хуудсыг ажиллуулдаг.

Зөвлөн туслах үйлчилгээ, оюутныг хөгжүүлэх чиглэлээр Сургалтын алба, Оюутны холбоо, Дотуур байрны зөвлөлүүд тогтмол ажилладаг. Жил бүр оюутны сэтгэл ханамж, сургалтын чанарыг сайжруулах зорилгоор 7-н асуулга бүхий тандалт судалгааг цахимаар

явуулдаг.

Оюутны эрүүл мэнд, ёс зүйг дээшлүүлэх зорилготой 6 төрлийн лекц, видеог вэбэд байршуулсан. Мөн эрүүл мэндийн төвийг ажиллуулж тогтмол үзлэг болон яаралтай тусламжийн үйлчилгээг үзүүлдэг.

Шинжээчийн үнэлгээ:

Оюутанд амжилттай суралцах, ажиллах, амьдрахад чиглэсэн үйл ажиллагааны хүртээмж хангалттай сайн.

Оюутны сэтгэл ханамжийн судалгааны дүнд үндэслэн дараагийн хичээлийн жилийн ажлын төлөвлөгөөгөө гаргадаг циклийг бүрдүүлэн ажиллах шаардлагатай.

Дүгнэлт: 5.2 шаардлагыг *БҮРЭН ХАНГАСАН* байна.

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Баримт нотолгоо:

ШУТИС-ийн хэмжээнд оюутны 29 клуб үйл ажиллагаагаа явуулдаг. Оюутнуудтай уулзах уулзалтын үед “My club”, “Хөтлөгчийн клуб”-үүдэд хамрагддаг оюутнууд клубын үйл ажиллагаа, клубт хамрагдахын ач холбогдлын талаар тайлбарласан.

Тухайн хөтөлбөрийн оюутнуудад зориулсан “Printing technology” клуб ажилладаг.

Оюутнуудын нийгмийн идэвхи оролцоог дээшлүүлэх, авьяас чадвар, хичээлийн үр дүн, урлаг спортын амжилтыг харгалзан ШУТИС-ийн болон ҮТС-ийн захирлын нэрэмжит тэтгэлэг олгодог. Өөрийн үнэлгээний тайлант хугацаа (2013-2018) нд Хэвлэлийн үйлдвэрлэлийн технологи хөтөлбөрийн 11 оюутан тус тэтгэлэгийг хүртсэн.

Шинжээчийн үнэлгээ:

ШУТИС-ийн хэмжээнд оюутнуудын идэвхи оролцоо, сайн дурын ажлыг дэмжих оюутны клубүүд хангалттай ажилладаг. Цаашид эдгээр клубүүдэд хөтөлбөрийн оюутнуудын хамрагдалтыг нэмэгдүүлэх нь чухал байна.

Тухайн хөтөлбөрийн оюутнуудад зориулсан “Printing technology” клубын үйл ажиллагааг тогтмолжуулах, оюутнуудыг бүрэн хамруулах нь оюутнуудын мэргэжилдээ дур сонирхолтой болгох, мэргэжлийн холбоотой мэдээлэл солилцоход дэмжлэг болно.

Дүгнэлт: 5.3 шаардлагыг *БҮРЭН ХАНГАСАН* байна.

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Баримт нотолгоо:

ШУТИС-ийн оюутнуудын шилжилт хөдөлгөөнийг ШУТИС-ийн Захирлын 2014 оны 04 сарын 14 өдрийн А/64 тоот “ШУТИС-ийн бакалаврын үйл ажиллагааг зохицуулах журам”-ийг мөрдөн зохицуулдаг.

Өөрийн үнэлгээний тайлант хугацаанд (сүүлийн 5 жил) шилжин явсан 45, шилжин ирсэн 3 оюутан байна. Үүнээс бусад сургуульд шилжсэн 15, сургуулиас гарсан 11, сураггүй 22 оюутан байна.

Шинжээчийн үнэлгээ: Шилжилт хөдөлгөөнийг суралцагчийн эрх ашиг, хүсэл сонирхолд нийцүүлэн шийдэж байна. Шилжин явсан оюутнуудын талаар дэлгэрэнгүй судалгаа хийж, шалтгааныг илрүүлэх, сургуулиа орхихыг аль болох багасгах чиглэлээр ажиллах нь зүйтэй.

Дүгнэлт: 5.4 шаардлагыг БҮРЭН ХАНГАСАН байна.

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Баримт нотолгоо:

Оюутны төгсөлтийн баримт бичгийг “ШУТИС-ийн бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”-ын дагуу зохицуулдаг.

Шинжээчийн үнэлгээ:

Хэвлэлийн үйлдвэрлэлийн салбарын хурдацтай хөгжил, зах зээлийн боломж нь энэ салбарт боловсон хүчний эрэлт хэрэгцээ байгааг илтгэж байна. Иймд мэргэжлийн нэр хүндийг өсгөх, зөв сурталчилгаа хийж, элсэгчдийн тоог нэмэгдүүлэх нь чухал юм. Мөн Хэвлэлийн үйлдвэрлэлийн технологи хөтөлбөрийг сонгон элссэн оюутнуудыг тогтвортой, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэх зорилгоор мэргэжлийн уралдаан тэмцээн, тэтгэлэг, урамшууллын тогтолцоог сайжруулах, оюутны оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн ажлуудад анхаарах шаардлагатай.

Дүгнэлт: 5.5 шаардлагыг БҮРЭН ХАНГАСАН байна.

ШАЛГУУР 5. ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ:

Сүүлийн 5 жилийн байдлаас үзэхэд элсэлтийн тоо буурч, хөтөлбөрөөр суралцагчийн тоо буурч байна. Энэ нь хэвлэлийн үйлдвэрлэлийн технологийн салбарт ажил эрхлэх, мэргэжлээрээ асах дэвжих талаар мэдээлэл муу байгаатай холбоотой учир ШУТИС, ҮТС-ийн зүгээс анхаарч ажиллах асуудал болж байна. Оюутны тоо цөөн байгаа ч тэднийг дэмжсэн үйлчилгээг ШУТИС-ийн бусад оюутны нэгэн адил авч байна.

Шинжээчийн дүгнэлт: Суралцагчдад чиглэсэн үйл ажиллагаанд тавих шалгуурыг БҮРЭН ХАНГАСАН байна.

Зөвлөмж:

1. Элсэлтийн тоог нэмэгдүүлэх, элсэн оюутнууд сургууль, хөтөлбөрөө орхихгүйгээр давхар мэргэших боломжийг бүрдүүлэх

Шалгуур 6. БАГШИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Баримт нотолгоо:

ШУТИС-ийн Захирлын 2018 оны А/168 тоо тушаалаар баталсан “Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн мэргэжлийн салбар, тэнхимийн үйл ажиллагааг зохицуулах журам”-ын дагуу багшийн сонгон шалгаруулалтыг явуулдаг.

“Хэвлэлийн үйлдвэрлэлийн технологи” хөтөлбөрт 10 багш ажиллаж байна. Үүнээс шинжлэх ухааны доктор (Sc.D.)-ын зэрэгтэй багш 1 (10%), доктор (Ph.D.)-ын зэрэгтэй багш 4 (40%), магистрын зэрэгтэй багш 5 (50%) байна.

Тус хөтөлбөрийн багш оюутны харьцаа 1:8 байгаа нь их сургуульд тавигдах нийтлэг шаардлагад бүрэн нийцэж байна.

Хэвлэлийн үйлдвэрлэлийн хөтөлбөрийн багш нараас Монгол Улсын Зөвлөх инженер 1, Тэргүүлэх инженер 1, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонт 1, Алтан гадас одонт 2, Хөдөлмөрийн хүндэт медалийн шагналтай 2, Засгийн газрын болон салбарын хүндэт жуух бичгийн шагналтай 4 багш байна. Мөн ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн шагналтай 1 багш, Захирлын нэрэмжит шагналтай 1 багш байна.

Шинжээчийн үнэлгээ:

Хэвлэлийн үйлдвэрлэлийн технологи хөтөлбөрийн багш нарын эрдмийн зэрэг цол болон багш оюутны харьцаа нь их сургуульд тавигдах нийтлэг шаардлагад бүрэн нийцэж байна. Багшийн нөөц болон ур чадварын хувьд хангалттай бэлтгэгдсэн нь хөтөлбөрийн давуу тал болж байна. Дүгнэлт: 6.1 шаардлагыг **БҮРЭН ХАНГАСАН** байна.

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Баримт нотолгоо:

ШУТИС-ийн “Багшийн хөгжлийн төв” нь 2015 онд ШУТИС-ийн Захирлын А/238 тоот тушаалаар байгуулагдсан. Их, дээд сургуулийн багш нарын мэргэжлийн хөгжлийг дэмжих зорилготой байгуулагдсан захиргааны анхны нэгж болсноороо онцлогтой.

ШУТИС-ийн Захирлын 2010 оны 116 тоот тушаалаар баталсан “Профессор багш, ажилтан, ажилчдыг шагнаж урамшуулах журам”-ыг баримтлан багш нарын ажлын үр дүнг үнэлж, урамшуулдаг.

ШУТИС-ийн захирлын 2016 оны А/131 тоот “ШУТИС-ын оны шилдэг багш шалгаруулах журам”-ын дагуу профессор багш нарыг шалгаруулдаг. 2013 онд хөтөлбөрийн багш Д.Дамдинсүрэн “Шилдэг зөвлөх багш”, 2014 онд “Топ 100 багш”, 2015 онд профессор Л.Удвал “Шилдэг судлаач багш”, 2016 онд Ц.Оюунчимэг “Топ 100” багшаар шалгарч байсан. 2016 онд Б.Баянжаргал Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн “Шилдэг залуу багш” номинацид 2 дугаар байр эзэлсэн.

ШУТИС-ийн хэмжээнд инженерийн боловсролын шинэчлэлийн санаачилга CDIO арга зүйг нэвтрүүлэх ажил хийгдэж байгаа бөгөөд тус төслийн хүрээнд багш нар олон улсын сургалт семинаруудад оролцож байна. Тус хөтөлбөрийн багш Д.Батбаяр, Б.Цолмон, Б.Баянжаргал нар 2018 онд 3 удаагийн олон улсын сургалт, семинаруудад оролцсон.

Шинжээчийн үнэлгээ:

Багшийн хөгжлийн төвөөс хичээлийн жилийн эхэнд батлагдсан төлөвлөгөөний дагуу багшийн хөгжлийг дэмжих олон талт сургалтууд зохиогддог бөгөөд энэхүү сургалтуудад Хэвлэлийн үйлдвэрлэлийн технологи хөтөлбөрийн багш нарын хамрагсан байдал хангалттай сайн байна.

Тус хөтөлбөрийн багш нарын мэргэжил дээшлүүлэхэд зарцуулсан төсөв нь 2015 оноос 2018 онуудад буурсан үзүүлэлттэй байсан бол 2019 онд өссөн үзүүлэлттэй байна. Цаашид багшийн мэргэжил дээшлүүлэх төсвийг бууруулахгүй бодлого баримтлах нь чухал юм.

Дүгнэлт: 6.2 шаардлагыг **бүрэн хангасан** байна.

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Баримт нотолгоо:

Монголын хэвлэлийн үйлдвэрүүдийн холбоо болон тус хөтөлбөрийн багш нар хамтран Монгол Улсын хэмжээнд мөрдөх “Хэвлэлийн бүтээгдэхүүний чанарт тавих шаардлага MNS

6789:2019” стандартыг боловсруулсан.

Тус хөтөлбөрийн 7 багшийн 15 ном, сурах бичиг, гарын авлагыг хэвлүүлсэн байна. Үүнээс тайлант хугацаанд хамаарах 4 бүтээл байна.

Хэвлэлийн үйлдвэрлэлийн технологи хөтөлбөрийн багш нар улсын захиалгат, гэрээт ажил нийт 8-ыг хэрэгжүүлсэн. Төслүүд нь НҮБ, БШУЯ, Монголын хэвлэлийн үйлдвэрүүдийн холбоо, Дулааны дөрөвдүгээр цахилгаан станцуудын захиалгат болон хамтарсан төслүүд бөгөөд өөрийн үнэлгээний тайлант хугацаанд хамаарах төсөл дөрөв байна.

Тайлант хугацаанд хөтөлбөрийн багш нар гадаадад 4, дотоодод 40 өгүүлэл хэвлүүлж, эрдэм шинжилгээний хуралд 8 илтгэл хэлэлцүүлсэн. Л.Удвал, Д.Дамдинсүрэн, Ц.Оюунчимэг багш нарын бүтээлээс нийт 30 удаа ишлэл авсан байна.

Шинжээчийн үнэлгээ:

Багш нарын судалгааны ажил болон төсөл гэрээт ажлуудын үр дүнд “Хэвлэлийн үйлдвэрлэлийн технологи” хөтөлбөрийг бакалавр, магистр, докторын түвшинд бүрэн шинэчилсэн сайн үзүүлэлттэй байна.

Дүгнэлт: 6.3 шаардлагыг *БҮРЭН ХАНГАСАН* байна.

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Баримт нотолгоо:

2017 оноос “Багшийн үнэлгээний систем”-ийг боловсруулсан бөгөөд багш вэб хуудсаараа дамжуулан өөрийн үнэлгээг хийх боломжтой болсон. Энэ систем нь багшийн сургалт, эрдэм шинжилгээ, нийгэмд чиглэсэн үйл ажиллагааг үнэлэх 3 дэд бүлэг, 1000 оноогоор үнэлэх үнэлгээний асуумж, нотолгоог татаж оруулах бүтэцтэй. Өөрийн үнэлгээний тайлан, ажлын тайланг үндэслэн салбарын эрхлэгч, сургалт хариуцсан дэд захирал үнэлгээ хийн урамшуулал болон багшийн зэрэглэлийг ахиулах саналыг сургуулийн захиргаанд хүргүүлдэг.

ШУТИС-ийн захирлын 2018 оны А/159 тушаал “Профессор багш нарын ажлын гүйцэтгэлийг кредитээр үнэлэх журам”-ын дагуу Профессор багшийн нэг хичээлийн жилд гүйцэтгэх ачаалал 20 багц цаг байх ба албан тушаалын зэрэглэлээс хамаарч “А”, “Б”, “В” багц цагийн хэмжээ харилцан адилгүй байдаг. “Профессор” зэрэглэлд ажиллаж буй багшийн “А” цагийн хэмжээ 11 багц цаг бол “Б” цагийн хэмжээ 6 багц цаг, “В” цагийн хэмжээ 2 байна. “Дэд профессор” зэрэглэлд ажиллаж буй багшийн “А” цагийн хэмжээ 13 багц цаг, “Б” цагийн хэмжээ 5 багц цаг, “В” цагийн хэмжээ 2 байна. “Ахлах багш” зэрэглэлд ажиллаж буй багшийн “А” цагийн хэмжээ 14 багц цаг, “Б” цагийн хэмжээ 4 багц цаг, В цагийн хэмжээ 2 багц цаг байна. “Багш” зэрэглэлд ажиллаж буй багшийн “А” цагийн хэмжээ 16 багц цаг, “Б” цагийн хэмжээ 2 багц цаг, “В” цагийн хэмжээ 2 байна. “Дадлагажигч багш” зэрэглэлд ажиллаж буй багшийн “А” цагийн хэмжээ 13+4 багц цаг, “Б” цагийн хэмжээ 1 багц цаг, “В” цагийн хэмжээ 2 байна.

Улирал бүр хичээл заасан оюутнуудаас багшийн ур чадвартай холбоотой 9 асуулга бүхий судалгааг авдаг. Оюутнууд асуулгуудад 0-5 оноогоор үнэлгээ өгдөг бөгөөд тухайн хөтөлбөрийн багш нарын үнэлгээний дундаж 4,65 оноо байна.

Шинжээчийн үнэлгээ:

Багшийн ажлын ачаалал, үнэлгээний систем бүрэн төлөвшсөн. Хөтөлбөрт хамрагдаж буй багш нарын ажлын амжилт хангалттай сайн байна.

Дүгнэлт: 6.4 шаардлагыг *БҮРЭН ХАНГАСАН* байна.

ШАЛГУУР 6. ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ:

Хэвлэлийн үйлдвэрлэлийн технологи хөтөлбөрийн эрдмийн зэрэг цолтой багшийн эзлэх

хувь 50% байна. Хөтөлбөрт оролцогч багш нарын судалгаа шинжилгээний ажлын гүйцэтгэл хангалттай сайн. ШУТИС-ийн хэмжээнд Багшийг урамшуулах, үнэлэх тогтолцоо сайн төлөвшсөн. Тус хөтөлбөрийн багш нарын амжилтын үзүүлэлт сайн.

Шинжээчийн дүгнэлт: Багшийн үйл ажиллагаанд тавих шалгуурыг БҮРЭН ХАНГАСАН байна.

Шалгуур 7. ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ, БАТАЛГААЖИЛТ

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Баримт нотолгоо:

ШУТИС-ийн Хэвлэлийн үйлдвэрлэлийн технологи хөтөлбөрийг тасралтгүй сайжруулахад чанарын баталгаажуулалтын үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, үйл явцыг тодорхойлох дараах журмуудыг мөрдөн ажиллаж байна. Үүнд:

- ШУТИС-ийн Захирлын 2009 оны 162 тоот тушаалаар баталсан “ШУТИС-ийн Дотоод хяналт шалгалтын журам”;
- 2017 онд батлагдсан “ШУТИС-ийн хөтөлбөрийн хорооны журам” батлагдсан. Энэхүү журмыг дагалдан ШУТИС-ийн Захирлын 2014 оны А/76 тоот тушаалаар баталсан “ШУТИС-ийн Хөтөлбөрийн хороо”, ШУТИС-ийн Захирлын 2014 оны А/164 тоот тушаалаар баталсан “ШУТИС-ийн салбар чиглэлийн хөтөлбөрийн дэд хороо”-ны бүрэлдэхүүн тус тус байгуулагдаж ажиллаж байна.

ШУТИС-ийн Захирлын 2012 оны А/63 тоот тушаалаар “Заах арга зүйн зөвлөл” байгуулагдсан. Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн заах арга зүйн зөвлөл нь 2012-2014 он хүртэл дотоод хяналт, шинжилгээг хийсэн. Энэхүү ажлын хүрээнд зөвлөлийн гишүүд нээлттэй хичээл зохион байгуулах, багш нарын хичээлд сууж туслан зөвлөх үйлчилгээ үзүүлж, залуу багш нарт ахмад багш нарын туршлагыг түгээн дэлгэрүүлэх ажлуудыг зохион байгуулсан. 2014 оноос Заах арга зүйн зөвлөлийн үүргийг хөтөлбөрийн дэд хорооны гишүүд хүлээн ажиллаж байна.

Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын удирдлага, зохион байгуулалт, эргэх холбооны схемийг гаргасан. Үүнд хөтөлбөрт оролцогч талууд (оюутан, төгсөгч, ажил олгогч, багш, удирдлага, чанарын баталгаажууллын нэгжүүд) хөтөлбөрийг сайжруулахад ямар үүрэгтэй хэрхэн оролцох уялдаа холбоог гарган үзүүлсэн.

ШУТИС-ийн захирлын тушаалаар 2018 онд Чанарын хяналт, шинжилгээ, үнэлгээний албыг албаны дарга, ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн гэсэн 3 орон тоотой байгуулсан. Чанарын дотоод баталгаажуулалтын ажлыг хөтөлбөрийн дэд профессор удирдан, хяналт тавьдаг. “ШУТИС-ийн чанарын менежментийн тогтолцооны гарын авлага батлах тухай” ШУТИС-ийн захирлын 2020 оны А/46 тоот тушаал гаргасан боловч тайланд тусгагдаагүй байна.

Шинжээчийн үнэлгээ:

Цаашид чанарын баталгаажуулалтын хөтөлбөр боловсруулан ажиллахаар төлөвлөж байгаа нь сайшаалтай. Хэвлэлийн үйлдвэрлэлийн технологи хөтөлбөр нь чанарын дотоод баталгаажуулалтыг хийхдээ хөтөлбөрийн үр дүнг хөтөлбөрийн зорилго, зорилт, ШУТИС болон салбарын хөгжлийн зорилтод нийцэж байгааг хянаж, бүх оролцогч талуудын оролцоог жигд ханган ажилладаг нь хөтөлбөрийг тасралтгүй сайжруулах үйл явцад дэмжлэг үзүүлдэг.

Дүгнэлт: 7.1 шаардлагыг *БҮРЭН ХАНГАСАН* байна.

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

Баримт нотолгоо:

Хөтөлбөрийн төгсөгчдийн ажил эрхлэлтийн мөшгөх судалгааг сүүлийн 4 жилийн байдлаар явуулахад сүүлийн жилийн байдлаар ажил эрхлэлтийн хувь нийт төгсөгчдийн 76,5%, хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа 17,6%, суралцаж байгаа 5,9% гэсэн үзүүлэлт гарсан.

Ажил олгогчдоос авсан судалгааны дүнд “Тус хөтөлбөрийн төгсөгчид нь танай байгууллагын хэрэгцээ, шаардлагыг хэрхэн хангаж байна вэ?” гэсэн асуудланд “Хангалттай” хариултыг нийт судалгаанд оролцогчдын 63,2%, “Дундаж” хариултыг 26,3%, “Хангалтгүй” хариултыг 10,5% нь хариулжээ. “Төгсөгчдийн ямар мэдлэг ур чадвар хангалттай гэж үзэж байна?” асуултад 94,7% нь онолын мэдлэгийг хангалттай эзэмшсэн гэж хариулсан бол гадаад хэлний мэдлэгийг 0% гэж үнэлжээ.

Ажил олгогчийн хэрэгцээ шаардлагыг хангах чадвартай төгсөгч бэлдэн гаргахад чиглэсэн нэг ажил нь хэвлэлийн үйлдвэрүүдтэй хамтын ажиллагааны гэрээг байгуулж, оюутнуудыг дадлага хийлгэх, цалинтай цагийн ажил хийлгэх хүрээнд хамтран ажилладаг.

Ажил олгогчидтой хийх уулзалтанд оролцсон ажил олгогчид 100 хувь тус хөтөлбөрийн төгсөгчдийг ажилд авах сонирхолтой. Шинэ төгсөгчид ажил олгогчийн шаардлагыг бүрэн хангах хангалттай чадвартай биш ч хэвлэлийн үйлдвэрлэлийн процесс, технологийг эзэмшсэн байдаг.

Шинжээчийн үнэлгээ:

Төгсөгчдөд онолын мэдлэгийг хангалттай өгч байгаа ч тэдний гадаад хэлний мэдлэгийг сайжруулахад онцгойлон анхаарах шаардлагатайг ажил олгогчид хэлсээр байна.

Ажил олгогчидтой хамтран үйлдвэрлэлийн дадлагыг зохион байгуулдаг нь сайн жишээ юм. Тухайн байгууллагад дадлага хийсэн оюутан төгсөөд тус байгууллагад ажилд орох магадлал өндөр байдаг байна.

Дүгнэлт: 7.2 шаардлагыг *бүрэн хангасан* байна.

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Шаардлагатай бол олгож буй эрдмийн зэрэг болон мэргэжлийн нэр хүндийг дэмжих зорилгоор үндэсний болон олон улсын байгууллагаар хөндлөнгийн үнэлгээ хийлгэдэг байна.

Баримт нотолгоо:

Олон улсын үр дүнд суурилсан сургалтын арга зүй болох CDIO сургалтын стандартыг ШУТИС-д нэвтрүүлэхтэй холбоотой хөтөлбөрүүдэд үнэлгээ хийж, шинэчлэх ажлыг хэрэгжүүлж, сургалтын шинэ арга зүйд тохируулан сайжруулах ажлыг зохион байгуулж байна.

Дээд боловсролын шинэчлэлийн төслийн хүрээнд “Дээд боловсролыг хөдөлмөрийн зах зээлтэй уялдуулах нь” зөвлөх үйлчилгээний боловсруулсан зөвлөмжийн дагуу төгсөгчдийн мөшгөх судалгааг зохион байгуулсан. Үүний үр дүнд төгсөгчдийн мэдээллийн бааз бүрдсэн.

Шинжээчийн үнэлгээ:

Хөтөлбөрийг хүлээн зөвшөөрүүлэх зорилгоор эрдмийн зэрэг болон мэргэжлийн нэр хүндийг дэмжих үндэсний болон олон улсын байгууллагаар хөндлөнгийн үнэлгээ хийлгэх нь чухал бөгөөд үүний нэг ажил нь хөтөлбөрийн магадлан итгэмжлүүлэх ажил юм.

Дүгнэлт: 7.3 шаардлагыг *ХЭСЭГЧЛЭН ХАНГАСАН* байна.

ШАЛГУУР 7. ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ:

Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтыг хангах чиглэлээр хийсэн ажлууд байгаа ч эдгээр ажлуудыг тогтмолжуулах, системтэйгээр үргэлжлүүлэх нь зүйтэй юм.

Шинжээчийн дүгнэлт: Чанарын баталгаажуулалтад тавих шалгуурыг БҮРЭН ХАНГАСАН байна.

Шаардлага:

1. Хөтөлбөрийг сайжруулах, нэр хүндийг өсгөх чиглэлээр оролцогч талууд, мэргэжлийн бусад байгууллагуудтай хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулж, тогтмол сайжруулалтыг хийх шаардлагатай. Хөтөлбөрийг хөгжүүлэхэд салбарын бусад байгууллагуудыг татан оролцуулах.

Зөвлөмж:

1. Чанарын үнэлгээний аргачлал, стандартыг тодорхой болгосноор хөтөлбөрийг хөгжүүлэх, тасралтгүй сайжруулах чиглэлд хийх ажлын стратеги төлөвлөгөө, зураглал, загварыг гарган, түүнийг мөрдөн хэрэгжүүлж ажиллах

ШИНЖЭЭЧИЙН НЭГДСЭН ҮНЭЛГЭЭ:

ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ

Шалгуур		Бүрэн хангасан шаардлага (2)	Хэсэгчлэн хангасан шаардлага (1)	Хангаагүй шаардлага (0)	Дүгнэлт
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	1.1 1.3	1.2		Бүрэн хангасан
2	Сургалтын үйл ажиллагаа	2.1 2.2 2.3			Бүрэн хангасан
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	3.1	3.2 3.3		Хэсэгчлэн хангасан
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	4.2 4.3 4.5	4.1 4.4		Бүрэн хангасан
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	5.1 5.2 5.3 5.4 5.5			Бүрэн хангасан
6	Багшийн үйл ажиллагаа	6.1 6.2 6.3 6.4			Бүрэн хангасан
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	7.1 7.2	7.3		Бүрэн хангасан
Нэгдсэн дүгнэлт		БҮРЭН ХАНГАСАН			

Өөрийн үнэлгээний тайлан, нотлох баримт, уулзалт ярилцлагын тэмдэглэлд үндэслэн шинжээчийн баг “Хэвлэлийн үйлдвэрлэлийн технологи” бакалаврын хөтөлбөр нь БМИҮЗ-ийн дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуурыг “ бүрэн хангасан” гэж дүгнэж байна.

Хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, чанарыг цаашид сайжруулах чиглэлээр дараах шаардлага, зөвлөмжийг өгч, шинжээчийн багийн дүгнэлтийг Инженерчлэл, үйлдвэрлэл, зохион бүтээлтийн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

ШИНЖЭЭЧИЙН ШААРДЛАГА

Шалгуур 1. Хөтөлбөрийн зорилго, агуулга	1. Хөтөлбөрийн зорилго, зорилтыг ажил олгогчдын төлөөлөл болон оролцогч талуудын төлөөлөл болох ажил олгогчдын зөвлөл, мэргэжлийн хөтөлбөрийн хороо зэрэг нэгжээр үе шаттай оролцуулж үнэлгээ дүгнэлт авч байх.
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, нөөц	2. Сүүлийн үеийн дэвшилтэт болон өсөн нэмэгдэж байгаа хэвлэлийн технологийн талаархи ном, гарын авлагыг нэмэгдүүлэх. 3. Сургуулийн төсөвт суулгуулан сургалтанд зайлшгүй шаардлагатай, өндөр хүчин чадалтай компьютертой болох.
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	4. Хөтөлбөрийн агуулга, хичээлийн цагийг шинэчлэх, ялангуяа оюутнууд төгсөөд ямар ажил дээр түлхүү ажиллаж байгаатай уялдуулан өөрчлөх шаардлагатай байна. 5. Хөтөлбөрийг марктенгийн идэвхжүүлэлтийн 5-н үндсэн зарчимд тулгуурлан /зар суртчилгаа, борлуулалтын урамшуулал, биечлэн худалдаа, олон нийтийн, шууд марктенгийн/ нэгдсэн хөтөлбөр гарган боловсруулах.
Шалгуур 7. Чанарын баталгаажуулалт	6. Хөтөлбөрийг сайжруулах, нэр хүндийг өсгөх чиглэлээр оролцогч талууд, мэргэжлийн бусад байгууллагуудтай хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулж, тогтмол сайжруулалтыг хийх шаардлагатай. Хөтөлбөрийг хөгжүүлэхэд салбарын бусад байгууллагуудыг татан оролцуулах.

ШИНЖЭЭЧИЙН ЗӨВЛӨМЖ

Шалгуур 1. Хөтөлбөрийн зорилго, агуулга	1. ШУТИС-ийн чанарын менежментийн тогтолцооноос гадна, хөтөлбөрийн зорилго, зорилт, суралцахуйн үр дүнг тасралтгүй сайжруулалт хийж байгааг нотлох “Хэвлэлийн үйлдвэрлэлийн технологи” хөтөлбөрийн бодлогын баримт бичигтэй байх
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, нөөц	2. Лабораторийн нэг суудалд ноогдох стандарт талбайгаас бага /1.07м ² , 1.2м ² , 1.60м ² / байгаа нь суралцагчдын суралцах таатай орчинг сайжруулах, өрөөний талбайг нэмэх 3. Комьютерийн тоог нэмэх, хүчин чадлыг сайжруулах, лаборатори болон дадлагын хичээлийн материалын төрөл зүйлийг нэмэх. 4. Үйлдвэрлэлийн дадлагын талаархи бүхий л мэдээллийг хангасан ирц, өдөр тутмын дадлагын ажлаар хийх сэдэв, юу сурч мэдсэн, юу хийсэн, яаж ажилласан, ажилд хандах хандлага зэрэг олон үзүүлэлтээр боловсруулсан оюутан тус бүрт дэвтэртэй /А4 товхимол/ болох 5. ШУТИС-ийн хэвлэлийн газарт дадлага хийдэг тухай

	тайланд бичигдсэн боловч үйлдвэрийн машин, тоног төхөөрөмж ажиллах цагийн тоог нэмэх, дадлагажигч нарын ажиллах өдрийн тоо, хугацааны талаар ШТУИС-ийн хэвлэлийн газартай гэрээ байхгүй байна.
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	<p>6. Хөтөлбөрийн агуулга, хичээлийн цагийг шинэчлэх, ялангуяа оюутнууд төгсөөд ямар ажил дээр түлхүү ажиллаж байгаатай уялдуулан өөрчлөх шаардлагатай байна.</p> <p>7. Мэргэжлийн багш нарын тоог нэмэх замаар хэвлэлийн шинэ технологийн хичээл оруулах, мөн хичээлийн агуулга, арга зүйг сайжруулах, дадлагын хичээлүүдийг нэмэгдүүлэх</p> <p>8. Олон улсын төсөл, хөтөлбөрүүдтэй хамтран ажиллаж, санхүүжүүлтийн нэмэлт эх үүсвэртэй болох боломжийг судлаж ажиллах</p>
Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	9. Элсэлтийн тоог нэмэгдүүлэх, элсэн оюутнууд сургууль, хөтөлбөрөө орхихгүйгээр давхар мэргэших боломжийг бүрдүүлэх
Шалгуур 7. Чанарын баталгаажуулалт	10. Чанарын үнэлгээний аргачлал, стандартыг тодорхой болгосноор хөтөлбөрийг хөгжүүлэх, тасралтгүй сайжруулах чиглэлд хийх ажлын стратеги төлөвлөгөө, зураглал, загварыг гарган, түүнийг мөрдөн хэрэгжүүлж ажиллах

Мэргэжлийн зөвлөлд уламжлах санал:

- Хөтөлбөрийн шинэчлэл хийсэн бол 4-н жилийн дараа итгэмжлүүлэх,
- Өөрийн үнэлгээний тайланг засвар оруулах хугацааг оруулж өгөх 1 сарын хугацаатай.
- Нотлох баримтыг хавсралтаар өгч байх

Шинжээчийн багийн ахлагч	Ө.ГАНБАТ
Шинжээчийн багийн гишүүн	С.АЛТАНТУЯА
Шинжээчийн багийн гишүүн	Д.ОДСҮРЭН

IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

№	Багшийн нэр	Албан тушаал	Заадаг хичээл	Утас	Майл хаяг
1	Д.Дамдинсүрэн	Профессор	<ul style="list-style-type: none"> ▪ Хэвлэлийн материал судлал, ▪ Хэв бэлтгэх технологи, ▪ Тоон хэвлэлийн технологи, ▪ Сав баглаа боодлын технологи дизайн, 	91999840	Damdinsuren_d@must.edu.mn
2	Ц.Оюунчимэг	Дэд профессор	<ul style="list-style-type: none"> ▪ Бичвэр мэдээлэл боловсруулах технологи, ▪ Дүрсэн мэдээлэл боловсруулах технологи, ▪ Өнгөний менежмент, ▪ Хэвлэлийн үйлдвэрийн төсөл, ▪ Хэвлэсний дараах технологи 	99908182	Omi_ppec@gmail.com
3	Б.Цолмон	Ахлах багш	<ul style="list-style-type: none"> ▪ ХЭБПХ-1, ▪ Хэвлэх процессын технологи 1, ▪ Хэвлэх процессын технологи 2, ▪ Дижитал гэрэл зураг, ▪ Хэвлэлийн чанарын удирдлага 	89001304	Tsolmon_b@must.edu.mn
4	Б.Баянжаргал	Ахлах багш	<ul style="list-style-type: none"> ▪ Хэвлэлийн үйлдвэрийн үндэс, ▪ ХЭБПХ-3,5, ▪ Номзүй, ▪ Хэвлэлийн бүтээгдхүүний хэрэглээ, ▪ ХЭБПХ 	91990388	Bayanjargal_b@must.edu.mn
5	Ү.Батжаргал	Багш	<ul style="list-style-type: none"> ▪ ХЭБПХ-2, ▪ Гэрлийн техникийн, үндэс ▪ Хэвлэлийн үйлдвэрийн тоног төхөөрөмж 	86941194	batjargalu@must.edu.mn

II. Оюутны нэрс

№	Оюутны нэрс	Курс, түвшин	Сонгосон байдал	Утас	Майл хаяг
1	Ч.Буриад	4	Орон нутаг	88422412	chimeddorjburiad@gmail.com
2	Д.Саруултөгс	4	УБ	89360316	B171200001@mymust.net
3	Г.Бямба-Анун	4	Орон нутгийн	99739092	Aanu420@yahoo.com

4	Б.Ану	4	Хөгжлийн бэрхшээлтэй	91666404	B171200004@mymust.net
5	Г.Мишээлт	4	УБ	99158765	B171200009@mymust.net
6	Б.Цэнгүүнжаргал	4	УБ	91090917	Tsenquunee.p@gmail.com
7	Ц.Отгонтуяа	4	Орон нутгийн	89281236	Otgontoya.2526@gmail.com
8	Б.Хасбагана	4	УБ	99923646	Xasaa111111@yahoo.com
9	Г.Батням	3	Орон нутаг	91677271	Batnyam0217@gmail.com
10	Б.Бумантогооч	3	Орон нутгийн	99369970	Bbumaa_58@yahoo.com
11	М.Өлзий-Орших	3	УБ	86072045	B161200001@mymust.net
12	Г.Лхагва	3	Орон нутгийн	80138856	B171200005@mymust.net
13	А.Отгонсүрэн	3	УБ	94292799	Snow_8_otgoo@yahoo.com
14	П.Тэмүүлэн	1	Орон нутгийн	94611707	purewdorjtemuulen@gmail.com
15	З.Батмөнх	1	Орон нутгийн	88955558	b.magic.gank@gmail.com
16	У.Нямбуу	1	УБ	99210052	uunyambuу@gmail.com

III. Ажил олгогчдын нэрс

№	Ажил олгогчийн нэр	Байгууллага, албан тушаал	Утас	Майл хаяг
1	Т.Ганхуяг	Хөх принт, захирал	99115065	Ganaat7711@gmail.com
2	Г.Хулан	Соёмбо принтинг, ерөнхий технологич	99686878	Hulan.esh@gmail.com
3	Ц. Энхзаяа	Мөнхийн үсэг, Үйлдвэрийн дарга	99070829	enkhzayatseveenregzen@gmail.com
4	С.Чинтуяа	Алмаз пресс, зарирал	99290616	Almazpress11@gmail.com
5	Д.Одгэрэл	Улаанбаатар принт, үйлдвэрийн дарга	99015224	b.odgerel@tavanbogd.com
6	Б.Отгонбаяр	Засгийн газрын хэвлэх үйлдвэрийн дарга	99158015	Otgonbayar.jp.gmail.com

IV. Төгсөгчдийн нэрс

№	Төгсөгчийн нэр	Төгссөн он	Байгууллага, албан тушаал	Утас	Майл хаяг
1	Нарангуа	2013	Мөнхийн Үсэг ХХК, эх бэлтгэгч дизайнер	99072271	Narka.0025@gmail.com
2	Хонгорзул	2013	Үнэт цаас ХХК, дизайнер	99645799	Khongoroo735@gmail.com
3	Батцэцэг	2013	ЗГ-ын хэвлэх,	88043283	g.baaqii2001@yahoo.com

			технологич		
4	М.Ууганцэцэг	2014	Алмаз пресс, дизайнер	88934143	uugancecegm@gmail.com
5	Мөнхжаргал	2015	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн хэвлэх, эх бэлтгэгч, дизайнер	88002418	Munkhjargal.do@legalinstitute.mn
6	Эрдэнэтөгс	2015	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн хэвлэх, эх бэлтгэгч, дизайнер	80053997	erdenetugszagdaa@gmail.com
7	Энхтуяа	2016	Алмаз пресс, дизайнер	95121120	Enkhtuya9420@gmail.com
8	Баасангарав	2016	Санко маркетинг, дизайнер	89100141	Baska.bb@gmail.com
9	Болор	2017	Соёмбо принтинг, дизайнер	91364949	Bolor0467@gmail.com
10	Чинзориг	2017	Мон лабель, хэвлэгч	98234567	bavuuchinzo@gmail.com
11	Баярмаа	2017	Хөх монгол принтинг, менежер	88110573	davaasambuubayarma@yahoo.com
12	Лхамжав	2017	Соёмбо принтинг, дизайнер	88967312	Lkhama0212@gmail.com
13	Булганбаяр	2018	Линограф, эх бэлтгэгч, дизайнер	90141039	Buuba0212@gmail.com
14	Марал- Эрдэнэ	2018	Линограф, хэвлэгч	95555503	
15	Доржханд	2018	Соёмбо принтинг, дизайнер	99380701	Dorjhand.ed@gmail.com
16	Самбууням	2018	Соёмбо принтинг, дизайнер	96130713	Sambuunyam_sn@yahoo.com

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

/албан бичгийг оруулах/

ҮІ. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо)
[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Шаардлага, зөвлөмж

ҮІІ. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо)
[Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Шаардлага, зөвлөмж

-